

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Г Санхүүгийн зохицуулах хорооны 7  
2008 оны 294 дүгээр тогтоолын зарим заалтын  
хэрэгжилтийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэсэн “Монголбазальт” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 75 491 900 ширхэг энгийн хувьцаанаас нийтэд санал болгон гаргах 36 000 000 ширхэг хувьцааг анхдагч зах зээлд арилжаалалгүй жил гаруй болсон, “Монгол базальт” ХК-иас 2010 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/03, 2010 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 1-62 тоот албан бичгээр хүсэлт ирүүлснийг тус тус ТЭМДЭГЛЭН:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 9.8 дахь заалт тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Тус Үнэт цаасны танилцуулгыг 2010 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн дотор шинэчлэн ирүүлэх хүртэл Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 294 дүгээр тогтоолын 2 дугаар болон 7 дугаар заалтын хэрэгжилтийг түдгэлзүүлсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд хүсэлт, холбогдох баримтыг ирүүлээгүй тохиолдолд уг үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болсонд тооцохоор тогтсугай.

3. Хорооноос зохих шийдвэр, зөвшөөрөл өгөх хүртэл уг үнэт цаасыг анхдагч зах зээлд нийлүүлэхгүй байхыг “Монголын хөрөнгийн бирж” /Р.Содхүү/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН